

## Халууны хувирал дахь зүрхний өвчний шинж тэмдэг, эмчилгээний онцлогийг харьцуулсан судалгаа

Ганбаатар А.<sup>1</sup>, Золзаяа Б.<sup>1</sup>, Эрдэнэчулуун Ж.<sup>2</sup>, Ван Хуан<sup>2</sup>

<sup>1</sup>ӨМӨЗО-ны Үндэстний их сургууль

<sup>2</sup>Монгол эм, эмнэлгийн дээд сургууль

e-mail:amar.ganbaatar83@gmail.com

### Abstract

#### Diagnostic and treatment feature of heart – disease in fever change

Ganbaatar A.<sup>1</sup>, Zolzaya B.<sup>1</sup>, Erdenechuluun J.<sup>2</sup>, Wang Huan<sup>2</sup>

<sup>1</sup>Doctorial degree student of Inner Mongolia National University

<sup>2</sup>Mongolian Drugs and Medicine College

e-mail:amar.ganbaatar83@gmail.com

### Introduction

Mostly fever change influences for heart and vital vessel and it is important for future treatment to compare difference of diagnosis and treatment feature of heart-disease in fever change.

### Goal

To compare difference of pain, feature, treatment and diagnosis when reduced fever change in heart

### Materials and Methods

The study was conducted using methods of 'Comparing manuscript sources studies', 'Analyses and syntheses' for determining numbers and described with 'Hermeneutics' methodology. The study was based on approved methodology and ethical review in December 2018

### Result

Fever could be directly matter of death because it should be needed to pay attention for method of treatment, to make research for general medicine of fever, to make research other organs & heart, to take medicine within ice sweet, to reduce fever and to treat through cautery, oily cream and ointment.

### Conclusion:

1. Most diagnostic and pain of fever influence for heart and it depends on process of fever accordance with our research collection.
2. It is possible to consider similarly pain, diagnosis and treatment of heart pneumonia and heart fever based on classification of general heart disease of science of medicine.

**Keywords:** Heat illness transformation, heart disease, symptoms, treatment, comparison

Рр. 35-38, References 16

### Оршил

Орчин үеийн байгаль эхийн хувьсал, техник технологийн шинэчлэл нь хүмүүний хэрэглээ, хоол хүнсэнд эрс өөрчлөлтийг авчирснаар вирус бактерийн эмгэг төрөгчөөр үүсгэгдсэн халдварт болон халдварт бус олон төрлийн

өвчин сүүлийн жилүүдэд нилээд гарч байна. Эдгээр өвчнүүдийн ихэнх нь уламжлалт анагаах ухааны онолын үзэл баримтлал хийгээд одоох судалгаагаар халуун өвчний шалтгаан, шинж тэмдэгтэй дүйж байгаа нь харагдаж байна [1, 2]. Уламжлалт анагаах ухаанд аливаа өвчнийг мөн

чанарынх нь үүднээс халуун, хүйтэн өвчин гэж 2 ангилал бөгөөд халуун өвчний явц хурдан, төрөл зүйл олон, эндүүрэл ихтэй, танин барьж анагаахад бэрх, дэлгэрэхдээ хялбар, түргэн амийг булаадаг хэмээн үздэг юм [3, 4].

Тиймээс уламжлалт анагаах ухаанд халуун өвчний талаархи бүхий л талын цогц шинжилгээ судалгааг хийх нь зүйтэй бөгөөд халуун өвчний хувиралыг ахуйн үесээр нь эс боловсорсон, дэлгэрсэн, хоосорсон, нуугдсан, хуучирсан, булингартсан хэмээн зургаа мөн язгуураар нь гэмтсэн, хямарсан, хижгийн, хорын хэмээн дөрөв ангилдаг бөгөөд [4, 5]. Эдгээр халууны хувирал дахь зүрхний өвчний шинж тэмдэг, оношлогоо, эмчилгээний онцлог шинж чанар болон ялгаатай талыг харьцуулан судлах нь цаашид эмчилгээний чухал ач холбогдолтой юм.

### Материал, арга зүй

2018 оны 12 сарын 11ний өдөр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Тунгиао хотын Өвөр Монголын Үндэстний Их сургуулийн багш нарын бүгд хурлаас судалгааны сэдэв, аргачлал, ёс зүйн хурлын шийдвэрийг үндэслэн судалгааны гол хэрэглэгдэхүүнээр “Цог төгөлдөр анагаах ухааны дөрвөн үндэс”-ийг эх сурвалж болгон халуун өвчний шинж тэмдэгийг дэлгэрүүлэн бичсэн байдлыг үндэслэн 2005 онд Төвдын “mi rigs dpe skrun khaṅ”-д хэвлэгдсэн анагаах ухааны 90 боть зохиолоос “Эх бичиг сурвалж судлалыг харьцуулах арга”-ыг ашиглан тус бүр 2 [6], 9 [7], 42 [8], 53 [9], 81 [10] дэх ботийг түүвэрлэн авч “Анализ синтезийн арга”-аар шинж тэмдэг болон эмчилгээг харьцуулж, “Герменевтикийн”-ийн аргаар тайлбар хийсэн болно.

### Зорилго

Халуун өвчний (ахуй үесийн 6, язгуурын 4) хувиралтаар зүрхний өвчинд нөлөөлөх идээ ундаа, явдал мөр, зовиур, шинж тэмдэг, эмгэг жам, эмчилгээний онцлогыг харьцуулан судлах.

### Зорилт:

1. Халуун өвчний хувиралууд зүрхэнд буусан үеийн зовиур, биед гарах шинж тэмдэгүүдийг түүвэрлэн онцлог чанарыг тодорхойлох.
2. Халуун өвчний хувиралууд зүрхэнд буусан үеийн идээ ундаа, явдал мөрийн онцлогыг харьцуулах.
3. Халуун өвчин зүрхэнд буусан үеийн эм, заслын эмчилгээг харьцуулж, онцлог чанарыг судлах.

### Үр дүн

Зовиур, шинж тэмдэгийн онцлог: Ахуй үесийн зургаа, язгуурын дөрвөн халууны хувиралууд бүгд зүрхэнд бууж зовиур болон шинж тэмдэг үзүүлдэг байх бөгөөд халуун өвчний явц, байдалтай уялдаж өөр өөрийн онцлог шинж чанартай байна. Үүнд

1. Дэлгэрсэн халуун Зовиур - мунхуурах, мэдрэл нь тодорхойгүй болох, хувцас хунараа ураг, нойр ба ундаасах нь их, дур хаагдах, хөхөн дээр хатгуулах. Шинж - Хэл нь хатаад гол нь харлах [1, 2, 7, 8, 9].
2. Хоосорсон халууны Зовиур - Нойр, өвдөлт хатгалгаа зэрэг нь бага, бие нь хөших бөгөөд шүд нь зуурч унтах цагт их ярина, Шинж - Бие нь халуун, судас нь богино, хатуу [1, 2, 6, 8].
3. Нуугдсан халууны Зовиур - Бүрийд нойр сэргэг, өдөртөө сүүдэрт суух дуртай, архи уусны сүүлээр дурьтал нь тодорхойгүй болох бөгөөд сэтгэл нь долгиох. Шинж - Хумс нь цайж, ар нуруу, өвчүү, нүүрээр нь ихэд хорхойн гөвдрүү гарах буюу мах нь алаг болдог [6, 8, 9, 10].
4. Хуучирсан халууны Зовиур - Хуучирсан халуун хий үгүйн шинж хөдөлсөн цагт уушги, зүрх долгиох, чичрэх, цээжин бие халуун оргих, дөрвөн мөч дээд, доодгүй хүндэрч бадайрах, зүрхэндээ хүйтэнг хүснэ [1, 2, 3, 6, 7]. Шинж - Нүүр тослогтоно [3, 6, 7, 8].
5. Булингартсан халууны Зовиур - Бие хүчгүй, нойр их, ам хатна, зүрхэндээ сэрүүнийг хүснэ [1, 5, 6, 7]. Шинж - Бие шарлаж, шээс улаан, шар, энгэсэг адил, нүдний үүл шар, хэл, буйл, хумсны өнгө алдагдана. Судас нь нарийн, ёроолдоо түргэн [3, 5, 6, 7, 9, 10].
6. Гэмтсэн халууны Зовиур - Хэлгийрэх бөгөөд хөдөлвөл үхэдхийх, дурьтал нь тодрохгүй, унтвал цочиж сэрэх, хөх, суга, дал хооронд хатгуулах. Шинж - Нүдний судал нь хөөх (томорч улайх) [5, 6, 7, 9, 10].
7. Хямарсан халууны Зовиур - Зүрхэнд буувал хөх, суга дагуу хатгуулж өвдөх, дурьтал нь тодорхойгүй болж дэмий өгүүлнэ. Шинж - Нүд улайж, хэл нь хатах [1, 3, 7, 9].
8. Хижгийн халууны Зовиур - Гөвдрүү хижиг зүрхэнд буувал уурлана, чичирнэ, цочих нь бага [1, 3, 7, 9, 10]. Шинж - Цэр нь цайвар хөвсгөр, хэл нь богино, ам хамар нь хүйтэн бол үхнэ [1, 2, 3, 7].

Идээ ундаа, явдал мөрийн оцлог: Халуун өвчин зүрхэнд буусан үеийн идээ ундаа, явдал мөрийг ялгавартай өгүүлээгүй боловч халуун өвчний үеийн ерөнхий эмчилгээний хэсэгт идээ ундаа, явдал мөрийн талаар дурьдсан байна. Идээ ундаанд: Цагаан будаа, хэмхэлсэн арвай, гашуун ногоо, үхэр, гөрөөс, ямааны мах, цасны ус, үнээ, ямааны тараг, айраг, сүү г.м хэрэглэхээр заажээ. Явдал мөрөнд: Сэтгэлд зохистой сэрүүн газар шүтүүлж өдөр унтах, хүнд хатуу ажил хийх, уурлах, их ярих, дуу чимээ ихтэй газар байхыг тэвчих ба ялангуяа гал наранд өдөр унтаж хүнд, тослог, шимтэй хоол, мах, архиийг тэвчих бөгөөд хэрвээ халуун өвчин өчүүхэн үлдвэл бие нь гэмтсэн манжинтай адил болдог тул идээ явдал мөрийг сар болтол сайтар цээрлэнэ [3]. хэмээсэн нь халууны урхагыг явдал мөрийн гам сайтар сахих хэрэгтэйг сануулжээ.

Эм, заслын онцлог: Халуун өвчин зүрхэнд буусан үеийн эмчилгээг түүвэрлэн харьцуулахад халуун өвчний эмчилгээний суурин дээр зүрхний өвчинд хэрэглэгдэх эмийг нэмэлтээр хэрэглэхийг заажээ. Бидний түүвэрлэн авсан нийт 48 жор, найрлагаас "Анагаах ухааны дөрвөн үндэс" [3]-т 15 жор, бусад дэлгэрүүлэн үзсэн зохиолд 23 жор, үүнээс жорыг нэрлэж бичсэн 19 жор, эм тус бүрээр найруулж бичсэн нь 29 жор, найрлага байна. Үүнд Агар-15 эм 5 удаа, Шүн Агар-8 эм 3 удаа, Гүргүм-7 эм 3 удаа, Сорогзин-11 эм 2 удаа тус бүр эмчилгээнд хэрэглэх тоогоороо голлож байхад эм тус бүрээр найруулж бичсэн жорын найрлаганд Агарын дан ургамал 18 удаа, Занданы дан ургамал 17 удаа, Задийн дан ургамал 13 удаа, Арүрийн дан ургамал 12 удаа, Жуганы дан ургамал 11 удаа, Гүргэмийн дан ургамал 11 удаа, Ниншошын дан ургамал 10 удаа, Лишийн дан ургамал 9 удаа, Жүрүрийн дан ургамал 9 удаа г.м эмийн ургамалууд орох тоогоороо тэргүүлж байна. Эдгээр эмчилгээний дараа хоосорсон халуунаас бусад халууны үед зэчүн, нодга, жэза, тонзаг хувь тааруулан ханаж, төөнүүрт VI, VII үес, гарнагцам төөнөх юмуу гурван үрийн тосон эм, дөрвөн толиог тослох зэргээр халууны сүүлийг хураахаар заажээ.

### Ном зүй

1. Эрдэнэчулуун Ж., Цэрэндагва Д., Мөнхтулга Л., Лхагвасүрэн Ц. Липополисахарид болон эшерихи бактерээр өдөөгдсөн халууралтын загвар дээр халуун өвчинг судалсан үр дүн, УБ, 2013, х.11-56
2. Бүрэндэлэг. Монгол анагаах ухааны халуун өвчний уг цогц, Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо,

### Хэлцэмж

Аливаа вирус, бактериар үүсгэгдсэн үрэвсэлт өвчин нь уламжлалт анагаах ухааны ойлголтонд халуун өвчний хувирал буюу эмгэг жамуудын нэг байж болохыг судлаачид судалсаар байна [4, 11, 12,13,14].

Эдгээр халуун өвчин нь уушги болон зүрх гэсэн цул эрхтэнүүдийг ихэвчлэн гэмтээдэг юм [15, 16]. Одоогийн ханиад томуу элбэг тархаж буй өнөө үед үндсэн эмчилгээнээс гадна тухайн эрхтэнд бууж өвчин үүсгэж байгааг анхааран авч үзэж эмчилгээ оношлогоондоо ашиглах нь чухал юм. Гэвч онолын хүрээнд халуун өвчний эмгэг жам, явц, эмчилгээ оношилгооны нэгдсэн байдлыг одоох анагаах ухааны ойлголтод тулгуурлан хийсэн судалгаа, шинжилгээ ховор байсаар байна.

### Дүгнэлт:

1. Бидний судалгаанд түүвэрлэн үзсэн халууны хувиралын ихэнхи нь уушги, зүрхэнд бууж шинж тэмдэг болон зовиураа үзүүлдэг байх бөгөөд халуун өвчний шарын махбод нь орны эрхээр хийн махбодтой уялдаж хий шар хавсарсан шинж чанартай өвчин үүсгэдэг байна.
2. Халуун өвчин зүрхэнд буусан үеийн идээ ундаа, явдал мөр нь халууны хувиралуудын ерөнхий эмчилгээтэй адил хэрэглэж болох ба эм заслын онцлог шинж нь илүү ач холбогдолтой байж оношлогоо, эмчилгээний шинж чанартай байна.
3. Бидний түүвэрлэн авсан нийт 48 жор, найрлагаас Агар-15 эм 5 удаа, Шүн Агар-8 эм 3 удаа, Гүргүм-7 эм 3 удаа, Сорогзин-11 эм 2 удаа тус бүр эмчилгээнд хэрэглэх тоогоороо голлож байхад засал эмчилгээгээр халууны сүүлийг хураах нь чухал болохыг тодруулсан байна.

### Түлхүүр үг:

Рр. Халууны хувирал, зүрхний өвчин, шинж тэмдэг, эмчилгээ, харьцуулалт

2014, х.103-141

3. Ютиг Ёндонгомбо. "Анагаах ухааны дөрвөн үндэс" Төвд Монгол хадмал, доод тал, Үндэстний хэвлэлийн хороо, Бээжин, 1991, х.553-673
4. Ишбалжир. Дөрвөн рашаан, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1988, х.130-138

5. Ютог сарма Ёндонгомбо. Арван найман гишүүнт, доод дэвтэр, Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2013, х.951-952
6. མཁུ་ལྷན་ལག་བརྒྱུད་པའི་སློང་པོ་བརྟམ་པ་ཡི་དབེན་ཞུ་བ། mi rigs dpe skrun khan, 2005, х.150-162
7. མཁུ་ལྷན་ལག་བརྒྱུད་པའི་ལྷན་པོ་ལྷན་པོ་ལྷན་པོ། mi rigs dpe skrun khan, 2005, х.435-447
8. ལྷན་པོ་ལྷན་པོ་ལྷན་པོ་ལྷན་པོ་ལྷན་པོ། mi rigs dpe skrun khan, 2005, х.87-93
9. མཁུ་ལྷན་ལག་བརྒྱུད་པའི་ལྷན་པོ་ལྷན་པོ། (mi rigs dpe skrun khan, 2005, х.223-245
10. མཁུ་ལྷན་ལག་བརྒྱུད་པའི་ལྷན་པོ་ལྷན་པོ། mi rigs dpe skrun khan, 2005, х.76-94
11. Баярсайхан О., Цэрэндагва Д., Солонго Б. Туршилтын амьтанд уушгины цочмог загвар үүсгэж, Сороол-4 тангаар эмчилсэн зарим үр дүн, “Дорно дахины уламжлалт анагаах ухаан”, 2013, No4, х.49-51
12. Наранцэцэг Б., Наранцэцэг Ж., Амбага М., Солонго Х. Мембран-Редокси потенциалын 3 төлөв байдал ба хий, шар, бадганы кодчилол, “Дорно дахины уламжлалт анагаах ухаан”, 2013, No4, х.19-24
13. Оюунцэцэг Н., Хаснатинов М., Оюунбилэг Ж., Молор-Эрдэнэ П., Чимэдрагчаа Ч. Дэва-5 тан болон түүний найрлагуудын вирүсын эсрэг үзүүлэх шууд нөлөөг шувууны Томуугийн А хүрээний H3N8 вирүст судлах нь, “Эрүүл мэндийн шинжлэх ухаан”, 2014, No11, х.38-42
14. Нарсу Б., Амбага М., Саранцэцэг Б., Хүрэлбаатар Л. Хий, шар, бадган хайлж царцах тухай УАУ-ы онолын мөн чанарыг амьтанд үүсгэсэн элэгний хурц өвчний эмгэг загвар дээр судалсан дүн, Докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол, УБ, 2004, х.14-54
15. Гомболхүндэв. Эм заслын саран хаан, Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хороо, 2013, х.80-81,120-121,130-131
16. Лувсанчойрог. Анагаах ухааны битүүмжит увидас, Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2013, х.133-136

*Танилцаж, нийтлэх санал өгсөн:  
Академич Ч.Чимэдрагчаа*